

“АБТС ББСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны  
06 сарын 06-ны өдрийн хурлын 1 дүгээр тогтоолын хавсралт 11



## “АБТС ББСБ” ХХК-ИЙН ЦАЛИН УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

### 1. НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Цалин урамшууллын бодлого /цаашид “Бодлого” гэх/-ын зорилго нь “АБТС ББСБ” /цаашид “Компани” гэх/-ын цалин урамшууллын зарчмыг тодорхойлж, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Гүйцэтгэх удирдлагын баг болон компанийн нийт ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцоо, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тогтооход оршино.
- 1.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хороо нь компанийн цалин урамшууллын бодлогыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооны баталсан Компанийн засаглалын кодекс, эрх зүйн бусад баримт бичигт нийцүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.3. Бодлогод хэрэглэгдэх нэр томъёоны тайлбар:
  - 1.3.1. “ТУЗ” гэж компанийн Төлөөлөн удирдах зөвлөл,
  - 1.3.2. “Гүйцэтгэх удирдлага” гэж компанийн Гүйцэтгэх захирал,
  - 1.3.3. “Гүйцэтгэх удирдлагын баг” гэж ТУЗ-ийн гишүүдээс бусад гүйцэтгэх удирдлагын багийг газар хариуцсан захирлууд, ерөнхий менежерүүд,
  - 1.3.4. “Эрх бүхий албан тушаалтан” гэж ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх удирдлага, Гүйцэтгэх удирдлагын багийн газар хариуцсан захирлууд, Ерөнхий менежерүүд,
  - 1.3.5. “Компанийн ажилтан” гэж компанитай “Хөдөлмөрийн гэрээ” байгуулан ажиллаж байгаа ажилтныг,

### ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ

- 2.1. ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо /цаашид “Хороо” гэх/ нь Цалин урамшууллын талаар дараах чиг үүрэгтэй.
  - 2.1.1. Компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих
  - 2.1.2. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах
  - 2.1.3. Компанид мөрдөж байгаа ажилтны үр дүнтэй холбогдсон Компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх
  - 2.1.4. Батлагдсан төсвийн дагуу ТУЗ-ийн гишүүдэд цалин, урамшууллыг олгох;

2.1.5. Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын багцад гарах өөрчлөлтийг хянаж, ТУЗ-д зөвлөмж хүргүүлэх.

### **ГУРАВ. ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ЗАРЧИМ**

- 3.1. Хороо нь цалин урамшууллын талаар компанийн хэмжээнд баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 3.1.1. Цалин, урамшууллыг компанийн үйл ажиллагааны чиглэл, онцлогт тохируулан зах зээлд өрсөлдөхүйц хэмжээнд тогтоох,
  - 3.1.2. Ижил үнэлэмж бүхий хөдөлмөрт адил цалин, урамшуулал олгох,
  - 3.1.3. Цалин, урамшууллыг ур чадварт болон ажлын үнэлгээ, үр дүнд суурилж тогтоох,
  - 3.1.4. Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн өсөлтийн зохистой харьцаа болон инфляцын түвшинтэй уялдуулж бодит цалингийн өсөлтийг хангах,

### **ДӨРӨВ. ТУЗ-ИЙН ЦАЛИН УРАМШУУЛАЛ**

- 4.1. Хороо нь компанийн ТУЗ-ийн гишүүнд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, энэхүү тогтоосон хэмжээнд багтааж цалин урамшуулал олгох санал боловсруулах, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам болон ТУЗ-өөс тогтоосон бусад асуудлын хүрээнд дараах хэлбэрээр, зохистой хэмжээг тогтоож олгоно.
- 4.1.1. Хуралд оролцсон цалин
- 4.2. ТУЗ-ийн гишүүнд цалингаас гадна дараах хэлбэрийн урамшуулалт цалин, шагнал урамшууллыг ТУЗ-ийн хурлын шийдвэрээр олгож болно.
- 4.2.1. Компанийн жилийн үр дүнг үндэслэн олох урамшуулалт цалин
  - 4.2.2. Бусад шагнал урамшуулал
- 4.3. Хороо нь ТУЗ-ийн гишүүний хуралд оролцсон цалин, урамшуулалт цалин, шагнал урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.
- 4.4. Хороо нь өөрийн хариуцсан чиглэлээр ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх ба тайлангийн жил дууссаны дараа гишүүн бүрийн үйл ажиллагаанд дүгнэлт өгч урамшуулалт цалин, шагнал урамшууллын хэмжээг тогтоож болно.
- 4.5. ТУЗ-ийн гишүүдэд бодитоор олгосон цалин, урамшуулалт цалин, шагнал урамшууллын хэмжээг ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааны тайланд тодорхой тусгана.
- 4.6. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын цалин ТУЗ тогтооно.

### **ТАВ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГИЙН ЦАЛИН**

- 5.1. Хороо нь компанийн Гүйцэтгэх удирдлага болон Гүйцэтгэх удирдлагын удирдлага дор ажиллах Дотоод аудитын алба, хуулийн зөвлөх, гүйцэтгэх удирдлагын багийн ажил үүрэг, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг тодорхойлно.
- 5.1.1. Хороо нь 5.1 дэх хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллыг тогтоохдоо мэргэшсэн, хараат бус зөвлөхийн зөвлөгөөг авч болно.
    - 5.1.1.1. Үндсэн цалин
    - 5.1.1.2. Богино болон урт хугацааны шагнал, урамшуулал

- 5.2. Гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулах, ажлын гүйцэтгэлийг дүгнэх, урамшуулал олгох, цалин шинэчлэн тогтоох үйл ажиллагааг Хороо боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөл батална.
- 5.3. Гүйцэтгэх удирдлагын багийн ажлын гүйцэтгэлд Гүйцэтгэх удирдлага үнэлгээ өгч дүгнэн урамшуулал олгох, цалинг шинэчлэн тогтоох шийдвэрийг гаргана.
- 5.4. Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоохдоо компанийн ашиг орлого, албан тушаалтны ажлын гүйцэтгэлтэй уялдуулсан байна.

### **ЗУРГАА. КОМПАНИЙН АЖИЛТНЫ ЦАЛИН, УРАМШУУЛАЛ**

- 6.1. Энэхүү бодлогод нийцүүлэн Монгол Улсын Засгийн газраас баталсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, байгууллагын ашигт ажиллагаа, бүтэц орон тооны төлөвлөлт, ижил төстэй байгууллагуудын цалингийн жишиг зэргийг харгалзан компанийн нийт ажилтны үндсэн цалинг Гүйцэтгэх удирдлага тогтооно.
- 6.2. Компанийн ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ эзгүй байгаа ажилтны үүргийг орон гүйцэтгэсэн, мэргэжил, ажил, албан тушаал хавсран ажилласан, шөнийн болон илүү цагаар ажилласан үед холбогдох журмын дагуу үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгох хэмжээг Гүйцэтгэх захирал тогтооно.
- 6.3. Компанийн ажилтны эрхэлж байгаа ажил, албан тушаалын онцлог, ажлын үр дүнгээс хамруулан тодорхой тайлант хугацаанд ажилтны үйл ажиллагааны гүйцэтгэл, компанийн орлогын төлөвлөгөөний биелэлт зэргийг харгалзан холбогдох журмын дагуу олгох шагнал урамшууллын хэмжээг Гүйцэтгэх захирал тогтооно.
- 6.4. Тухайн жилийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаа батлагдсан компанийн бизнес төлөвлөгөө болон инфляцын түвшинтэй уялдуулж Гүйцэтгэх удирдлагаас ажилтны цалин хөлс, урамшууллыг шинэчлэн тогтоож болно.

### **ДОЛОО. ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ**

- 7.1. Хороо нь компанийн цахим хуудсанд цалин, урамшууллын бодлогын баримт бичгийг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

### **НАЙМ. ХЯНАЛТ**

- 8.1. Хороо нь компанийн ажилтны цалин урамшуулалтай холбоотой дотоод дүрэм, журам, системийн үр дүнг үнэлж холбогдох хууль тогтоомжид нийцэж буй байдалд хяналт тавина.
- 8.2. Хороо нь энэхүү бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд ТУЗ-д танилцуулж, ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлнэ.